

ТАЙВАН ХУРАН ЦУГЛАХ ЭРХ ЧӨЛӨӨ НЬ ТАНСАГЛАЛ БОЛООД ДАВУУ ЭРХ БИШ ХАРИН ХҮНИЙ ҮНДСЭН ЭРХ.

ХҮНИЙ ЭРХИЙН ТҮГЭЭМЭЛ ТУНХАГЛАЛЫН 20 ДУГААР ЗҮЙЛ:

1. Хүн бүр чөлөөтэй, тайван хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхтэй.

**ИРГЭНИЙ БОЛОН УЛС ТӨРИЙН ЭРХИЙН ТУХАЙ ОЛОН УЛСЫН ПАКТЫН
21 ДҮГЭЭР ЗҮЙЛ:**

Тайван хуран цуглах эрхийг хүлээн зөвшөөрнө. Энэхүү эрхийг эдлэхэд ардчилсан нийгэмд үндэсний буюу нийгмийн аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах, эсхүл бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах эрх ашгийн үүднээс хуулийн дагуу тогтоосноос өөр хязгаарлалт хийж болохгүй.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН 16 ДУГААР ЗҮЙЛ:

Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

16.16 Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно.

ЖАГСАГЧДЫГ

ХАМГААЛ

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



**ТАЙВАН ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ
ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ БАЙХ
ЭРХИЙН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН
ХЭМ ХЭМЖЭЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИД
БАТАЛГААЖУУЛСАН ЭСЭХИЙГ
ХЯНАХ ХУУДАС**

(Хууль тогтоогч, бодлого боловсруулагчдад зориулав.)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН ТА

**“Жагсаал цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль”-ийн
төсөл нь олон улсын хүний эрхийн хэм хэмжээ, эрхийн
хамгаалалтын зарчмуудад нийцэж байгаа эсэхийг
шалгана уу.**



ТӨРИЙН ҮҮРЭГ

1

Тайван замаар жагсах эрхээ хэрэгжүүлэхэд нь аливаа байдлаар саад учруулахгүй байж, тайван замаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг нь **ХҮНДЭТГЭХ**

2

Гуравдагч этгээдийн зүгээс учруулж болзошгүй аливаа хүчирхийлэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай арга хэмжээг авч, жагсагчдыг **ХАМГААЛАХ**

3

Тайван замаар жагсаалаа үргэлжлүүлэх боломжит орчин нөхцлийг бий болгох зэргээр **ХАНГАХ ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ**

ТИЙМ ☒ ҮГҮЙ ☒

Жагсаал цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн төсөл доорх зарчмуудад нийцэж байгаа эсэхийг нягталж, анхаарна уу.

ЕРӨНХИЙ ЗАРЧИМ

☐ ЗАРЧИМ 1. ҮНДСЭН НЭР ТОМЬЁО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Эрх зүйн орчин нь жагсаал цуглааныг зохион байгуулахад үйлчлэх ёстой.

- Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй холбоотой үндсэн нэр томьёо оновчтой, бүрэн агуулгаар, тодорхой томъёологдсон байхыг баталгаажуулсан байх. Үүнд хувь хүн эсвэл бүлэг хүмүүс аяндаа хуран цуглах эсвэл зэрэгцээ байдлаар, дижитал технологи ашиглан цахим орчинд эсэргүүцлээ илэрхийлэх боломжтой байх ёстой бөгөөд “тайван” гэх нэр томьёог өргөн хүрээнд авч үзэх шаардлагатай.
- Жагсаал, цуглаантай холбоотой төрийн үүрэг нь зөвхөн хуулийн дагуу явагдаж байгаа жагсаал, цуглаан төдийгүй, хууль зөрчсөн боловч тайван журмаар явагдаж байгаа жагсаал, цуглаанд мөн хамаарна.

☐ ЗАРЧИМ 2. ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛСАН ХЭВ ЖУРАМ САХИУЛАХ ХАНДЛАГА

- Хууль сахиулах байгууллагууд жагсаал, цуглааныг хамгаалах, хангах үүргийг нэн тэргүүнд тавих ёстой. Тэдний арга барил нь Мэдэх, Дэмжих, Ярилцах, Ялгах гэсэн ойлголтод тулгуурласан байх.
- Үндсэн хууль, холбогдох бусад хуульдаа жагсаал цуглааны үеэр хэв журам хамгаалахаар цэргийн хүч дайчлахыг хориглох.

☐ ЗАРЧИМ 3: ҮЛ ЯЛГАВАРЛАЛ

Хүн бүр ялгаварлан гадуурхалтаас ангид байж хуран цуглах эрхээ эрх тэгш эдлэх боломжтой байх.

Үүнд арьс өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, хэл, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал, үндэсний цөөнх, харьяалал, өмч хөрөнгө хөгжлийн бэрхшээл, нас, хүйс, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл, болон бусад байдлаар ялгаварлагдан гадуурхагдахгүйгээр жагсаал цуглаан хийх эрхээ хүн бүр тэгш хэрэгжүүлэх боломжтой байх, бүх хувь хүн, бүлэг, бүртгэлгүй холбоод, хуулийн этгээд жагсаал, цуглаан хийх эрхтэй байхыг баталгаажуулах ёстой.

☐ ЗАРЧИМ 4: ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ХҮРЭЭ

Төрөөс хуран цуглах эрхэд тавих хязгаарлалт нь гагцхүү олон улсын хүний эрхийн эрх зүйд заасан үндэслэлийн хүрээнд байгаа эсэхийг нягтлах. Эрх баригчид хязгаарлалт тавих шаардлагыг онцгой тохиолдол гэж үзэх ёстой бөгөөд ийм хязгаарлалт нь тодорхой үндэслэлтэй болохыг нотлох үүргийг төр хүлээнэ. Үүнд:

- Хуулиар тогтоосон байх:** Хязгаарлалт нь аливаа зөрчлийн үр дагаврыг үнэлэх боломжтой, хангалттай нарийвчлан томъёолсон хуульд заасан үндэслэлтэй байх;
- Хууль ёсны зорилгодоо нийцсэн байх:** Үндэсний аюулгүй байдал, нийтийн хэв журам, нийгмийн эрүүл мэнд, ёс суртахуун, эсвэл бусдын эрх, эрх чөлөөг хамгаалахад чиглэсэн хууль ёсны зорилгодоо нийцсэн байх;
- Хууль ёсны зорилгоо хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай бөгөөд тохирсон байх:** Хязгаарлалт нь хэт өргөн хүрээг хамрах ёсгүй ба тодорхой, хувь хүнд чиглэсэн, хууль ёсны зорилгыг хамгаалах хамгийн бага хязгаарлалт байх ёстой.

☐ ЗАРЧИМ 5: ОНЦ БАЙДЛЫН ҮЕИЙН ЗОХИЦУУЛАЛТ

- Жагсаал цуглааныг хязгаарлахын тулд онц байдал зарлах арга хэмжээ авах ёсгүй.
- Онц байдлын үед ч тайван жагсаал, цуглаан хийх эрхээс ухрах ёсгүй.
- Улс орнууд хуран цуглахыг хориглосон эсвэл жагсаал, цуглаан хийх эрхийг хэрэгжүүлэхийг ямар нэгэн байдлаар хязгаарласан аливаа шийдвэрийг үр дүнтэй, цаг тухайд нь, хараат бус, шударга шүүхээр хянан шалгуулах баталгаагаар хангах ёстой.

☐ ЗАРЧИМ 6: ЖАГСААЛ ЦУГЛААН ХИЙХ ЭРХИЙН ХАМГААЛАЛТ

Олон улс, бүс нутгийн хүний эрхийн холбогдох гэрээг соёрхон баталж, дотоодын хууль тогтоомжид тусгах, хуран цуглах эрхийн хязгаарлалт нь үндэслэлтэй эсэхийг хараат бус, бие даасан шүүх, шүүх эрх мэдэл бүхий байгууллагаар шуурхай, бүрэн, үр дүнтэй хянуулах, эрх зөрчигдсөн тохиолдолд үр дүнтэй нөхөн сэргээх, Иргэний болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хохирол барагдуулах, урьдчилан сэргийлэх, шүүхийн бус нөхөн сэргээх арга хэмжээ авахыг баталгаажуулсан байх ёстой.

ТӨРИЙН ХҮНДЭТГЭХ, ХАМГААЛАХ, ХАНГАХ ҮҮРЭГ

☐ ЗАРЧИМ 7: ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЭРХ ЧӨЛӨӨ

Зарчим 3-т заасанчлан хүн бүр ямар нэг үндэслэлээр ялгаварлан гадуурхагдахгүйгээр хуран цуглах эрх чөлөөг эдлэнэ. Жагсаал цуглаан зохион байгуулах мэдэгдэл нь жагсаал цуглаанд төрөөс дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай зохицуулалтыг бий болгоход чиглэгдэх ёстой. Түүнчлэн аяндаа үүссэн тайван жагсаалыг хамгаалах, хүүхэд нь насанд хүрэгчдийн адил жагсах эрхтэй байхыг баталгаажуулсан байвал зохистой.

☐ ЗАРЧИМ 8: ЖАГСААЛ ЦУГЛААН ХИЙХ БАЙРШЛАА СОНГОХ ЭРХ ЧӨЛӨӨ

Хүн бүр жагсаал хийх газраа сонгох эрх чөлөөтэй байх бөгөөд сонгосон газар нь үзэл бодлоо илэрхийлэх зорилготой нь салшгүй холбоотой. Олон нийтийн газар жагсаал зохион байгуулах нь хууль ёсны болохыг хүлээн зөвшөөрч, зорилтот бүлэгтээ харагдахуйц, сонсогдохуйц зайд байх нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай. Мөн цахим орчинд эсэргүүцлээ илэрхийлэхэд хязгаарлалт тавихаас татгалзах ёстой.

☐ ЗАРЧИМ 9: ЖАГСААЛ ЦУГЛААНЫ АРГА, ХЭЛБЭРЭЭ СОНГОХ ЭРХ ЧӨЛӨӨ

- Хүн бүр жагсаал цуглаан хийх арга, хэлбэр, үргэлжлэх хугацаагаа сонгох эрх чөлөөтэй байх;
- Хүчирхийллийн бус шууд үйлдэл буюу иргэний үл захирагдахуйц эсэргүүцлээ илэрхийлэх хууль ёсны хэлбэр болохыг хүлээн зөвшөөрөх;
- Жагсаал, цуглааны үргэлжлэх хугацаанд хязгаарлалт тогтоохгүй байж, түр зуурын байгууламж барих, ашиглах, аудио хэрэгсэл ашиглах, цахим болон цахим бус орчинд эсэргүүцлээ илэрхийлэхдээ нэрээ нууцлах зэргийг хориглохгүй байх;
- Жагсаал, цуглааны үеэр интернэт, үүрэн телефоны сүлжээг тасалдуулахгүй байх зэргээр хүн бүр дижитал технологи ашиглах боломжтой байхыг баталгаажуулах ёстой.

☐ ЗАРЧИМ 10: ЖАГСААЛ, ЦУГЛААНЫ АГУУЛГА, ШАЛТГААНЫГ СОНГОХ ЭРХ ЧӨЛӨӨ

Хүн бүр жагсаал, цуглаан хийх агуулга, шалтгаанаа сонгох эрх чөлөөтэй байх ёстой. Аливаа хязгаарлалт нь Зарчим 4-т заасан шалгуурт нийцсэн, хуулиар хамгаалагдсан байхыг баталгаажуулах шаардлагатай.

☐ ЗАРЧИМ 11: ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЭРХИЙГ ДЭМЖИХ

Хууль сахиулах байгууллагууд жагсаал, цуглааныг аюул заналхийлэл хэмээн үзэж болохгүй. Төр өөрийн харьяалалд байгаа хүн бүрийн жагсах эрхийг баталгаажуулах эерэг үүрэгтэй. Үүнд бүх жагсаал, цуглааны үеэр хүний эрх хамгаалагдсан байх, жагсаал, цуглаанд саад учруулах гэсэн аливаа хэлбэрийн заналхийлэл, хүчирхийллээс жагсагчдыг идэвхтэй хамгаалах, жагсаал цуглааны ажиглагч, сурвалжлагч, эмэгтэйчүүд, хүүхэд, цөөнх, тусгай хэрэгцээт хүмүүс зэрэг ялгаварлан гадуурхалт, дайсгалд өртөж болзошгүй эрсдэлд байгаа бүлгүүдийг хамгаалах зэрэг багтана.

☐ ЗАРЧИМ 12: ЖАГСАГЧДЫН ЭСРЭГ ХҮЧ, АЛБАДЛАГА ХЭРЭГЛЭХ, ТАРААХ

- Жагсагчдын эсрэг хүч хэрэглэхийг хязгаарласан зарчим баримтална. Гагцхүү онцгой нөхцөлд, хүчирхийлэл үйлдсэн жагсагчдын эсрэг зайлшгүй шаардлагатай, тохирсон байдлаар хүч хэрэглэх ёстой. Түүнчлэн хүч хэрэглэсний улмаас гэмтэж бэртсэн, хохирсон хүн бүрт яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэхийг баталгаажуулах;

Энэхүү шалгах хуудаст олон улсын хүний эрхийн хэм хэмжээ, зарчмуудаас түүвэрлэн оруулсан бөгөөд хууль тогтоогчид, бодлого боловсруулагчид эдгээрийн дэлгэрэнгүйг QR кодоос үзнэ үү.

- Нийтийн эзэмшлийн зам талбайг хааж, замын хөдөлгөөнд саад учруулсан хүчирхийллийн бус иргэний үл захирагдахуйн үйлдлийг дан ганц бусдад саад учруулсан гэх үндэслэлээр тарааж эсвэл хориглож болохгүй. Хүчирхийлэл үйлдэгдсэн үед цагдаа нар юуны өмнө цуглааныг бүхэлд нь тараахын оронд хүчирхийлэл үйлдэгч этгээдэд анхаарлаа хандуулж, хүчирхийлэл тархахаас урьдчилан сэргийлэх ёстой. Оролцогчдод цагдаагийн хүч хэрэглэхгүйгээр сайн дураараа тарах боломжийг олгох ёстой.

☐ ЗАРЧИМ 13: ЖАГСАГЧДАД ХЯНАЛТ ТАВИХ, ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ

- Жагсаал, цуглаан зохион байгуулагч, оролцогчдыг биет орон зайд болон дижитал сүлжээгээр нийтээр нь хянах зорилгоор тандалтын арга техник ашиглахыг хориглох;
- Энгэрийн камер зүүх хууль сахиулагчидтай холбоотой шийдвэр нь зайлшгүй, тохирсон байх зарчмын дагуу хүний эрхэд үзүүлэх нөлөөллийг бүрэн харгалзан үзсэн байх ёстой.
- Жагсаал, цуглаанд оролцох нь дангаараа хэзээ ч эрүүгийн хэрэг үүсгэх, эрүүгийн хэрэгт оролцсон гэж сэжиглэх үндэслэл болох ёсгүй. Жагсаалын үеэр үйлдэгдсэн зөрчилтэй холбоотойгоор хувь хүнд эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэх нь нарийн тодорхой, хуулиар тогтоосон нөхцөлд, хууль дээдлэх ёсонд нийцсэн хараат бус, бие даасан шүүхийн шийдвэрээр хэрэгжих;
- Бусдын хийсэн үйлдэлд зохион байгуулагч, жагсагчдад шийтгэл хүлээлгэхгүйн тулд хариуцлага үргэлжид хувь хүнд чиглэсэн байхыг баталгаажуулах шаардлагатай.

☐ ЗАРЧИМ 14: ХАРИУЦЛАГА, ИЛ ТОД БАЙДАЛ

- Жагсаал, цуглаантай холбоотой төрийн байгууллагын шийдвэр гаргах бүх үйл явц ил тод, хүртээмжтэй, олон улсын зохих ёсны хэм хэмжээнд нийцсэн байх;
- Жагсаалын үеэр хэв журам хамгаалах арга техник, хүч хэрэглэх нь хараат бус, бие даасан, шуурхай хяналтын дор хэрэгжиж, олон нийтийн хараа хяналт дор байх тухай хуульд тусгаж, практикт мөрдөх.

☐ ЗАРЧИМ 15: МЭДЭЭЛЛИЙН ЧӨЛӨӨТ УРСГАЛ

- Жагсаал, цуглаантай холбоотой мэдээллийг өмнө нь, жагсаалын үеэр болон дараа нь хүн бүр хүлээн авах, түгээх боломжтой байлгахын тулд бүх төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээх чөлөөт урсгалыг бий болгох;
- Жагсаал, цуглааны үеэр хэв журам сахиулах ажиллагаатай холбоотой журам, төсөв, тайлан зэрэг гол мэдээллийг авах боломжтой байх, албан тушаалтан, хууль сахиулагчид гаргасан шийдвэр, үүргээ хэрэгжүүлсэн талаарх баримт мэдээллийг хөтөлж, хадгалдаг байх, тус баримт мэдээллийг олон нийт, хөндлөнгийн хяналтынхан авах боломжтой байх тухай хуульд тусгаж, практикт мөрдөх.

☐ ЗАРЧИМ 16: ЖАГСААЛ, ЦУГЛААНЫГ АЖИГЛАХ, МЭДЭЭЛЭХ

- Хэвлэл мэдээллийн бүх хэрэгсэл, хараат бус ажиглагчдад бүхий л байршилд жагсаал, цуглааныг ажиглах, сурвалжлахыг нь зөвшөөрч, зарчимд нийцээгүй хязгаарлалт тогтоохгүй байх;
- Жагсаал, цуглааны үеэр цагдаагийн үйл ажиллагаа, хүний эрхийн зөрчлийг баримтжуулсан нэг ч хүнийг жагсаал, цуглааныг сурвалжилж, мэдээлснийх нь төлөө шийтгэхгүй байх ёстой. Техник хэрэгсэл, хэвлэмэл материал, дуу, дүрсний болон бусад бичлэгийг зориуд хураан авах, гэмтээх, эвдэхийг завдсан үйлдэлд хариуцлага тооцох механизмыг бүрдүүлэх.

